

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

| | | | |
|---|--------------------------------|---------------------|------------|
| Ярилцлага өгөгчийн нэр | Дашгэмпэнлин хийдийн өвгөн лам | Дугаар | Л348 |
| Оршин суугаа аймаг | Дундговь аймаг | Оршин суугаа сум | Дэлгэрцогт |
| Төрсөн газар | Мандалговь | Төрсөн он | |
| Ажил мэргэжил | лам | | |
| Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд | Дэлгэрийн Чойр | Сүм хийдийн дугаар | ДУДЦ 034 |
| Одоогийн сүм хийд | Дашгэмпэнлин | Сүм хийдийн дугаар | ДУМХ 043 |
| Ярилцлага авсан он сар өдөр | 2007 оны 7-р сарын 10 | Ярилцлага авсан хүн | Жужа |



Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Дэлгэрийн Чойр

Жужа: Өнөөдөр 2007 оны 7 сарын 10-ны өдөр, Дундговь аймгийн Мандалговь хотод Дэлгэрийн Чойрын тухай ярилцахаар өндөр настан лам гуйтай ярилцаж байна. Та хэдэн настай лам болсон?

Өвгөн: Долоон настай лам болсон. 17-той би хар болсон. Гэмлэл гуй, Мятав гуй энэ тэр гэж мундаг мундаг лам нартай цуг байсан, надад хоёр гурван хурлын уншлага байсан.

Жужа: Та Богдын хүрээнд сууж байсан уу?

Өвгөн: Би 7 настайдаа Богдын хүрээнд шавилсан. Манай хоёр ч ах гавж, энэ тэр цолтой том лам нар явсан. Тэд нарынхаа хүчинд би Богдын хүрээ орж Зүүн хүрээнд шавилан жаахан юм сурсан. Тэгээд эргэж ирээд Чойрын хийдэд хоёр жил гаруй суугаад хурал хаасан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Та Зүүн хүрээнд аль аймагт сууж байсан бэ?

Өвгөн: Зүүн хүрээний 32 аймаг гэж байсан юм. Түүний Чойжилын аймагт сууж байсан. Чойжилын аймаг гэдэг чинь үндсэндээ Чойрын чигийн аймаг.

Жужа: Чойжилын аймагт та аль дацанд хурдаг байсан бэ?

Өвгөн: Би албан ёсоор хурдаггүй байсан. Ахыгаа дагаж л явсан. Хоёр том ахтай байсан хүн. Гавж ах, гэлэн ах гэж хоёр том ах.

Жужа: Таны үеийн лам нар байна уу, одоо?

Өвгөн: Гэмлэл, Мятав гэж хоёр сайхан лам байсан. Хоёулаа таалал боллоо. Одоо шавь нь болох Доолой гэж нэг хүн л байна даа.

Жужа: Та одоо ямар хийд дацанд хурал ном хурж байна?

Өвгөн: Би энэ аймгийн төвийн Дашгэмпэнлин хийдэд л хуралд хурж байна даа.

Жужа: Одоо энэ Дашгэмпэнлин хийдэд настай үлсүүд хэд байна?

Өвгөн: Хоёр гурван хүн байна даа. Надаас гурав ах, ерэн гуравтай Цогзол гэж нэг өвгөн байна. Би 89-тэй.

Жужа: Энэ хийд хэдэн онд нээгдсэн бэ?

Өвгөн: Дөрөв таван жил болж байна уу даа, тийм л байгаа байх. Гавихгүй ээ, гавиагүй.